



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/186

Улаанбаатар хот

Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага  
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2020 оны 152 дугаар тогтоол, 2024 оны 74 дүгээр тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/30, 2024 оны А/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 6 байршлын 6 нэгж талбарт газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр цахим хэлбэрээр зохих журмын дагуу зохион байгуулсугай.

2. Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, зориулалт, хэмжээ анхны үнийг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Багахангай дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 1-р сарын 16-ны өдрийн /16/ дугаар  
захирамжийн хавсралт

ЦАХИМ ХЭЛБЭРИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ,  
ЗОРИУЛАЛТ, ХЭМЖЭЭ, АНХНЫ ҮНЭ

| №  | Эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил                        | Зориулалт                                            | Газрын хэмжээ (м2-аар) | Газрын анхны үнэ (төгрөг) | Дэнчингийн төлбөр 10% (төгрөг) |
|----|--------------------------------------------------------------|------------------------------------------------------|------------------------|---------------------------|--------------------------------|
| 1. | БХД 1-р хороо, Өндөртолгой Онцгой байдлын хэлтсийн хойд талд | Авто машины засвар, үйлчилгээний газар               | 115                    | 138.000                   | 13.800                         |
| 2. | БХД 1-р хороо, Үйлдвэрийн бүсэд                              | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 475                    | 570.000                   | 57.000                         |
| 3. | БХД 1-р хороо, Үйлдвэрийн бүсэд                              | Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар        | 10000                  | 4.800.000                 | 480.000                        |
| 4. | БХД 2-р хороо, Хангай зөрлөг, авто замын баруун талд         | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 243                    | 243.000                   | 24.300                         |
| 5. | БХД 2-р хороо, Замчин гэр хорооллын баруун урд талд          | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 258                    | 309.600                   | 30.960                         |
| 6. | БХД 2-р хороо, Билгүүт, Улсын чанартай авто замын зүүн талд  | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 3011                   | 3.613.200                 | 361.320                        |